

ШҮҮХИЙН ХӨГЖИЛД ЦАХИМЖИЛТ, ХИЙМЭЛ ОЮУНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ



*Open World”
хөтөлбөрийн
хүрээнд зохион
байгуулагдсан
“Шүүхийн хараат
бус байдал ба
цахимжилт” олон
улсын бага хуралд
танилцуулсан
үндсэн илтгэл*

*(2025 оны 06 дугаар
сарын 16-ны өдөр)*

Та бүхний энэ өдрийн амар амгаланг дахин эрье.

Шүүхийн салбарт “тулгамдаж буй” нийтлэг асуудлуудын талаар нээлттэй санал солилцож, шийдэл ярилцаж, туршлага хуваалцахаар зорин ирсэн зочид, төлөөлөгчдөдөө талархал илэрхийлье.

Дэлхий даяар өсөн нэмэгдэж буй хэрэг маргааны тоо, хүний болон санхүүгийн “хязгаарлагдмал нөөц”, “хүрэлцээ”, “шүүхэд итгэх олон нийтийн итгэл”–тэр дундаа процессын шударга ёсны хэрэгжилт, сэтгэл ханамжийн сорилтуудыг үргэлж сэргэгээр анхаарч, оновчтой аргаар даван туулж, тогтолцоогоо сайжруулж байх нь шүүх эрх мэдлийн бие даасан байдал, цаашлаад “нийгмийн шударга ёсны тогтолцоо”-г бэхжүүлэх үндэс болно.

Монгол Улсын хувьд ч дээрх асуудлыг “анхаарлаас алдалгүй, манаж ажиллах шаардлага” урьд нь ч байсан, цаашид ч байх болно. Тухайлбал, эрүү, иргэн, захиргааны анхан шатны шүүхүүдийн 2013 онд шийдвэрлэсэн хэргийн тоо 2023 онд буюу сүүлийн 10 жилийн

хугацаатай харьцуулахад 86.76%-иар нэмэгдсэн, цаашид ч өсөх төлөвтэй байна.

Нэг талаас иргэд маргаанаа “шүүхээр шийдүүлэх хандлага дээшилж буй” нь чухал боловч **“нөгөө талдаа”** үүнд тохирсон шүүхийн нөөцийг нэмэгдүүлэх, үйл ажиллагаа, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай юм.

Ийм нөхцөлд шүүх асуудлыг “араас нь хөөж бус” харин “угтуулан төлөвлөж”, байгаа нөөцөөрөө улам илүү бүтээмжтэй, ухаалаг зохион байгуулалттай ажиллах шаардлага нэмэгдэж байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд “ухаалаг цахимжилт”, “мэдээллийн сайн технологи”, “дэвшилтэт хиймэл оюун”-ыг нэвтрүүлэх нь бидний гарц шийдэл гэдэг нь хэн бүхэнд илэрхий болжээ.

Тиймээс өнөөдрийн хурлаар бид шүүхийн цахимжилтыг өргөн болон тухайлсан агуулгаар олон сайн туршлага, шийдлүүдийг санал болгож, асуудлыг олон талаас нь шүүн тунгааж, санал бодлоо нээлттэй хуваалцана гэдэгт итгэл дүүрэн байна.

“... Ийм нөхцөлд шүүх асуудлыг “араас нь хөөж бус” харин “угтуулан төлөвлөж”, байгаа нөөцөөрөө улам илүү бүтээмжтэй, ухаалаг зохион байгуулалттай ажиллах шаардлага нэмэгдэж байна.”

Эрхэм мэргэжил нэгт нөхөд өө,

Та бүхэнд Монгол Улсын шүүхийн цахимжилтын өнөөгийн байдал, шүүхийн салбарт ашиглаж буй мэдээллийн технологийн талаар мэдээлэл өгөхийн зэрэгцээ шүүхийн хөгжил, шинэтгэлийн хүрээнд цахимжуулалтыг сайжруулах зарим асуудлаар санал бодлоо хуваалцъя.

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН САЛБАР ДАХЬ ЦАХИМЖУУЛАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Орчин үеийн шүүх нэг талаас хараат бус, шударга байх, **“нөгөө талаас”** үйл ажиллагаа, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах чиглэлд хөгжлийн бодлогоо төлөвлөх ёстой болжээ. Шүүхийг цахимжуулах, мэдээллийн технологийн дэвшилтэт хэрэгслүүд, хиймэл оюуныг нэвтрүүлэх зорилт нь эл хоёр талбарын аль алинд нь **“өгөөж”-өө** өгнө.

Монгол Улсад олон улсын сайн туршлагаас өөрийн онцлогоо харгалзан буулгаж шүүхийн чанарыг процесс, шийдвэрийн ба үйлчилгээний талбаруудаар тодорхойлж, тогтмол үнэлдэг байх хэрэгцээ байсаар байна.

Энэ утгаараа бидний нэвтрүүлэх “цахим тогтолцоо” нь шүүхийн үйлчилгээний “шуурхай”, “хүртээмжтэй”, “нээлттэй”, “ил тод”, “ойлгомжтой байдал”-ыг нэмэгдүүлэх зорилготой байх ёстой. Энэ нь шүүхийн үйлчилгээ үзүүлж байгаа болон тэрхүү үйлчилгээг авч буй талуудын “**хууль ёсны хэрэгцээ шаардлагаас**” урган гарч байгаа юм.

Олон улсын туршлагаас үзэхэд шүүхэд “баримт бичиг хайх, хянах”, “шийдвэр гаргахад туслах”, “хэргийг ангилах, хуваарилах болон ажлын урсгалыг автоматжуулах” зэрэг зорилгоор мэдээллийн технологи ашиглах нь түгээмэл байна. Тухайлбал, 2025 оны 2 дугаар сард Шүүхийн үр нөлөөт байдлын төлөөх Европын комиссын анхны тайланд мэдээллийн технологийн 8 төрлийн, 125 хэрэгслийг ашиглаж байгааг дурджээ.

“... Орчин үеийн шүүх нэг талаас хараат бус, шударга байх, “нөгөө талаас” үйл ажиллагаа, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах чиглэлд хөгжлийн бодлогоо төлөвлөх ёстой болжээ. Шүүхийг цахимжуулах, мэдээллийн технологийн дэвшилтэт хэрэгслүүд, хиймэл оюуныг нэвтрүүлэх зорилт нь эл хоёр талбарын аль алинд нь “өгөөж”-өө өгнө.”

Монгол Улсын шүүхийн хувьд дээрх тодорхой төрлийн ажиллагаануудыг 20 гаруй системийн тусламжтайгаар зохих хэмжээнд гүйцэтгэж, ойрын хугацаанд нэгтгэн хөгжүүлэхээр ажиллаж байна.

Хэрэглээний зориулалтаар нь багцлан тоймловол:

1. Шүүхийн шийдвэрийг нээлттэй байршуулах, шүүхээс гарсан шийдвэрүүдийг судлах боломж олгох платформ

Шүүхийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх зарчмын хүрээнд нууцад хамаарах, гэр бүлийн маргаан зэрэг хуульд заасан тодорхой төрлийн хэргээс бусад бүх шийдвэрийг цахим хуудаст нээлттэй, ил тод байршуулдаг. Өдгөө уг цахим хуудаст 2012 оноос хойших анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн нийт 547,000 гаруй шийдвэр нээлттэй байршиж байна.

Тодорхой асуудлаар өмнө нь гарсан шүүхийн шийдвэрүүдийг хайж олох, хууль хэрэглээг судлах, тэр хэрээр шүүхээс гарах шийдвэрийн

магадлалыг тооцоолж болох нээлттэй мэдээллийг бүрдүүлж, хайлтыг хугацаагаар, маргааны төрлөөр, түлхүүр үгээр, хэрэглэсэн хуулийн зүйл, хэсэг, заалтаар, шүүх, шүүгчийн нэрээр хайх технологийн шийдэлтэй болсон.

Энэхүү цахим платформыг сардаа нэг сая гаруй, өдөрт дунджаар 40,000 орчим хандалттайгаар иргэд, хуулийн салбарынхан өргөн хэрэглэж байна. Цаашид энэ платформд мэдээллийн хэт ачаалал үүсэх тул хэрэглэгчдийн цагийг хэмнэх үүднээс “хиймэл оюун” нэвтрүүлэх ажил, эрх зүйн үндэс “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого”-д тусгагдсан бөгөөд ойрын хугацаанд хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

“... Өдгөө уг цахим хуудаст 2012 оноос хойших анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн нийт 547,000 гаруй шийдвэр нээлттэй байршиж байна.”

2.Хувийн мэдээллийг нууцлах, нэргүйжүүлэх цахим шийдэл

Монгол Улсад 2021 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шүүхийн шийдвэрийг олон нийтэд нээлттэй байршуулахад нарийн шаардлага тавигдах болсон.

Шүүхийн шийдвэрт дурдсан хүн, хуулийн этгээдийн нэр, регистр, улсын бүртгэлийн дугаар, хаяг зэргийг нууцалж цахим хуудаст байршуулахад олон зуун хуудас материалыг гар аргаар хийх боломжгүй тул үүнийг хөнгөвчилсөн цахим шийдлүүдийг шүүхийн захиргааны байгууллага ашиглаж байна.

3.Ангилах, хуваарилах болон ажлын урсгалыг автоматжуулах систем

Шүүхийн цахимжуулалтаас олон улсуудад нэн түрүүнд хэрэглээнд нэвтэрсэн нь хэргийн хөдөлгөөний систем. Монгол Улс 2013 онд захиргааны хэргийн шүүхийн бүртгэл хяналтын систем, 2014 онд “Иргэн-2014” нэгдсэн систем, 2015 онд эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны бүртгэл тайлангийн программыг, 2017 онд Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийг тус тус бүх шатны шүүхүүдэд нэвтрүүлсэн. Үүнээс гадна төрийн мэдээлэл солилцооны “ХУР” цахим системээс шүүхэд хэрэг шийдэхэд шаардлагатай лавлагаа, тодорхойлолтыг “Шүүхийн цахим лавлагааны систем”-ээс татан авч, нотлох баримтаар ашиглах боломж бүрдсэн.

Мөн шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцуулахтай холбоотой олон талт системийг 2018 онд нэвтрүүлсэн.

4.Бичлэг хийх, шууд дамжуулах технологи

2012 оноос Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дагуу бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг дуу, дүрсний бичлэгээр баталгаажуулан хадгалдаг болсон бөгөөд 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс шүүх хуралдааны тов, тоймыг хэргийн оролцогч, сонирхогч этгээдэд нээлттэй байлгах шүүх хуралдааны явцыг мэдээлэх систем ашиглагдаж байна. Үүнээс гадна 2025 оны 01 дүгээр 01-нээс эхлэн Улсын дээд шүүхийн хуулиар хаалттай явагдахаас бусад шүүх хуралдааныг албан ёсны цахим хуудсаараа, Эрүүгийн хэргийн бүх шатны шүүхүүд авлигын гэмт хэргийн шүүх хуралдааныг мөн цахим хуудсаараа шууд дамжуулж эхэлсэн.

Энэ нь “хууль хэрэглээ”, шүүхийн үйл ажиллагааны талаарх “үнэн зөв”, “бодит мэдээлэл” хүргэх, “ил тод байдал”-аа дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлж буй алхам юм.

Харин шүүх хуралдааныг олон нийтэд нээлттэй хүргэх явцад хүний эрх, тэр дундаа хувийн халдашгүй байх эрхийг “хамгаалах”, пропорционал зарчмын хэрэгжилтийг хангах ёстой.

Монгол Улс шүүхийн цахимжилтыг дараагийн түвшинд гаргах зорилгоор олон улсын жишиг загвар болох “Хэргийн хөдөлгөөний цахим удирдлага”, “Цахим хавтаст хэрэг”, “Цахим шүүхийн систем”-ийг үе шаттайгаар нэвтрүүлэхээр ажиллаж, “Шүүхийн цахимжилт 2.0 систем”-ийг 2025 оноос эхлэн хөгжүүлж байна.

“... шүүх хуралдааныг олон нийтэд нээлттэй хүргэх явцад хүний эрх, тэр дундаа хувийн халдашгүй байх эрхийг “хамгаалах”, пропорционал зарчмын хэрэгжилтийг хангах ёстой.”

Шүүхэд хандан эрхээ хамгаалуулах хүсэлтэй иргэд орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах, цахимаар нотлох баримт хүлээн авах, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцтай танилцах зэрэг хэргийн хөдөлгөөний удирдлагыг

цахим байдлаар явуулаад зогсохгүй, прокурор, цагдаа болон төрийн бусад байгууллагуудын цахим платформтой мэдээллийг чөлөөтэй солилцдог болгон хөгжүүлэх ажлыг өрнүүлж, энэ оноос эхлэн анхан шатны зарим шүүх дээр туршилтын ажлыг эхлүүлсэн.

ХОЁР. ШҮҮХИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ЦАХИМЖИЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ

Шүүхийн цахимжилт нь **нэг талаас** шүүхийн үйлчилгээг авахаар ирсэн иргэдэд “ойлгомжтой”, “хэрэглэхэд хялбар”, “тэдний цаг, зардлыг хэмнэсэн байх”, **нөгөө талаас** шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын “ажлын чанар”-ыг алдагдуулахгүйгээр хөнгөвчилсөн байх шаардлагатай.

Шүүхэд цахимжилтыг сайжруулснаар шүүхийн үйлчилгээний шуурхай байдлыг ахиулах боломжтой.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар шүүхийн үйлчилгээ нь **“шуурхай байх”** зарчимтай. Гэвч шүүгч, шүүхийн захиргааны ажилчдын тоо цөөн, сул орон тоо нөхөгдөхгүй удах, хэргийн ачаалал өндөр байгаагаас энэ зарчим алдагдаж байна. Тухайлбал, 2024 онд нийслэлд иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч дунджаар 654 хэрэг маргаан шийдвэрлэсэн. Энэ нь шүүгчийн зохист ачааллын дээд хэмжээ болох 209 хэргээс даруй 3 дахин их байна.

Шүүхийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд цахимжилт чухал нөлөөтэй.

Бидний туршлагаас үзэхэд, шүүхэд цахимжилтын программ хангамж, мэдээллийн технологи, шаардлагатай тоног төхөөрөмжийг нэвтрүүлэхэд эхлэлийн зардал өндөр гардаг. Тиймээс аливаа цахимжилтыг нэвтрүүлэх, хөгжүүлэхэд түүний үр ашиг, өгөөж нь шүүхийн систем болон иргэдэд хэрхэн тусахыг “урьдчилан тооцоолох”, түүнийг төсөв батлах парламентад төдийгүй олон нийтэд “ойлгуулан таниулах” нь чухал ач холбогдолтой.

“... 2024 онд нийслэлд иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч дунджаар 654 хэрэг маргаан шийдвэрлэсэн. Энэ нь шүүгчийн зохист ачааллын дээд хэмжээ болох 209 хэргээс даруй 3 дахин их байна.”

“Цахим платформ” нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч иргэн, хуулийн этгээд, өмгөөлөгчид болон шүүхийн системд ажиллагсдын “хөдөлмөрийг хөнгөвчлөх”, шүүхэд биеэр ирэх тохиолдлын “тоог цөөлөх”, тэр хэрээр талуудын “зардлыг багасгах”,

“хугацааг хэмнэх” бодит үр нөлөөтэй байхаас гадна хүчин төгөлдөр үйлчилж буй **“хуулийн заалт бүрд нийцсэн”**, “аливаа хуулийн өөрчлөлтийг дагаж сайжрах” боломжтой байх учиртай.

Нөгөөтээгүүр, үзэл хандлагын хувьд цахимжуулалт шүүхийн хөгжил, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох хүчин зүйл гэдгийг бодлого гаргаж байгаа болон хэрэгжүүлж байгаа бүх хүн бүрэн хүлээн зөвшөөрч, “нээлттэй”, “уян хатан”, “эрүүл ухаан”-аар хандах ёстой.

Монгол Улсын шүүхүүдэд шүүх хуралдаанд хэргийн оролцогчдыг зайнаас оролцуулах ажлыг 2015 оноос үе шаттай зохион байгуулж 2021 оны 09 сар гэхэд нийт 35904 шүүх хуралдааныг амжилттай зохион байгуулсан. Энэ нь шүүхийн үйлчилгээг “хялбар”, “шуурхай” хүргэхэд “эерэг” үр нөлөөтэй болохыг харуулсан.

Алгоритмд нөлөөлөх эрсдэл ба шийдэл

Хэргийг шүүгчид хуваарилах ажиллагаа хөндлөнгийн нөлөөлөлгүй байх нь шударга ёсыг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шүүхийн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэх шууд хүчин зүйл бөгөөд **“Шүүх захиалгаар ажилладаг”** гэх ойлголтыг үгүйсгэх эхний шат юм.

Хэрэг хуваарилах системд хөндлөнгөөс оролцож шүүгчийг зориуд сонгох, хасах, өөрчлөх, ул мөр үлдээхгүйгээр бүртгэлийг нь устгах зэрэг хэрэг хуваарилалтын үндсэн зарчмыг алдагдуулах тохиолдол олон улсын хэмжээнд ч илэрсээр байна. “Санамсаргүй” хуваарилалт нэрийн дор кодчиллын түвшинд зохиомол өөрчлөлт хийх, шүүгчийн ачааллын тоог “алгоритм дотор”-оос зориуд бууруулах, өгөгдлийн баазад өөрчлөлт оруулах, админ эрхээр шүүгчийг шууд солих зэрэг тохиолдлууд байна. Энэ талаарх мэдээллийг илтгэлийн дэлгэрэнгүй болон слайдаас харж болно.

“... Нөгөөтээгүүр, үзэл хандлагын хувьд цахимжуулалт шүүхийн хөгжил, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох хүчин зүйл гэдгийг бодлого гаргаж байгаа болон хэрэгжүүлж байгаа бүх хүн бүрэн хүлээн зөвшөөрч, “нээлттэй”, “уян хатан”, “эрүүл ухаан”-аар

Кодчиллын хяналтгүй байдал нь шүүхийн хараат бус, ил тод байдал, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг шууд алдагдуулж, зөвхөн шүүгч гэлтгүй шүүхийн нэр хүнд бүхэлдээ унах, улс төрийн болоод авлигын сүүдэрт автсан тогтолцоог бий болгох сөрөг нөлөөтэй.

Хиймэл оюун ба цахимжилтын сорилт, боломжууд

“... Кодчиллын хяналтгүй байдал нь шүүхийн хараат бус, ил тод байдал, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг шууд алдагдуулж, зөвхөн шүүгч гэлтгүй шүүхийн нэр хүнд бүхэлдээ унах, улс төрийн болоод авлигын сүүдэрт автсан тогтолцоог бий болгох сөрөг

Саяхан шахуу онолын түвшинд яригдаж байсан ойлголт бодит амьдралд биеллээ олж, шинэ шинэ нээлтүүд энэ салбарт жилээр бус, сар, өдрөөр нэмэгдэж байна. Улмаар шүүхийн хувьд, **нэг талаас** энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэхэд “бэлтгэлтэй байх”, **нөгөө талаас** өөрсдийн үйл ажиллагаанд оновчтой арга, хэр хэмжээтэй нэвтрүүлж чадвал шүүхийн хөгжилд “дорвитой алхам”

болно.

Олон улсын жишигт, хиймэл оюуныг хэрэг маргааныг “төрөлжүүлэх”, “хурлын тов тогтоох”, “иргэдэд туслалцаа үзүүлэх”, “шүүхийн практик-хэрэг судлах”, “эвлэрүүлэн зуучлалд талуудыг тохиролцоонд хүрэх боломжийг дээшлүүлэх”, “шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх”, “орчуулга хийх”, “шүүхээс гарах шийдвэрийн магадлалыг тооцоолох” зэргээр шүүхийн системд хэдийн нэвтрүүлээд эхэлсэн.

Монгол Улсын шүүхийн хувьд “хиймэл оюун”-ыг шүүхэд шат дараатай нэвтрүүлэх талаар бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бөгөөд бэлтгэл ажил хангагдаж байна. Манай улсын шүүхийн шийдвэрүүд харьцангуй “**бүтэцлэгдсэн**” учир “цаг хугацаа, хөдөлмөр хэмнэх” томоохон давуу талтай юм.

Нөгөө талдаа “хиймэл оюун” нь алдаа дутагдлаас “ангид бус”, “өөрийн чадавхын хүрээнд” үр дүн боловсруулдаг, тухайлан “хариуцлага хүлээх чадамжгүй” гэдгийг бид мартаж болохгүй.

Хиймэл оюуны технологи нь шүүхийн үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэхэд бодит үр дүн авчирна.

“Хиймэл оюун” хэлний модульд тулгуурласан тул улс орнууд өөрсдийн хэл дээр, тэр дундаа хууль зүйн мэргэжлийн хэл дээр “шаардлага хангасан”, “итгэж болохуйц” хиймэл оюун хөгжүүлэхэд зайлшгүй “**цаг хугацаа**” шаардагдах болно. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн програмууд гадаадын олон хэл дээр ажиллах боломжтой ч “мэдээллийн аюулгүй байдал”, “үндэсний бодлого”, “эрх зүйн орчин”-ы хувьд сорилтуудтай тулгарна.

“Хиймэл оюун”-ы хэрэглээ нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдалд итгэх иргэдийн итгэлд шууд нөлөөлөх учраас олон улсад эрх зүйн орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарч байна. Энэ талаар Та бүхэн “слайд”-аас дэлгэрэнгүй харж болно.

“... Нөгөө талдаа “хиймэл оюун” нь алдаа дутагдлаас “ангид бус”, “өөрийн чадавхын хүрээнд” үр дүн боловсруулдаг, тухайлан “хариуцлага хүлээх чадамжгүй” гэдгийг бид мартаж болохгүй”

Хиймэл оюунд суурилсан шийдвэр гаргалтыг **“хяналтгүй”** хэрэглэсний улмаас хэргийг шийдвэрлэх шүүгчийн оюуны оролцоо бүдгэрэх, түүнчлэн алдаатай, шударга бус шийдвэр гарах, ялгаварлан гадуурхах болон хувь хүний нууцын хамгаалалтад эрсдэл үүсэж байгаа нь түгшүүр төрүүлж байгааг дурдах нь зүйтэй.

Эдгээрээс дүгнэхэд, дэлхий даяар шүүх эрх мэдэл “цахим технологи”, “хиймэл оюун”-д эргэлтгүй шилжиж эхэлжээ. Энэхүү шилжилт үндэсний цахим дэд бүтэц, эрчим хүчний нөөц чадамж, хүн амын боловсрол, салбарын санхүүжилтээс шалтгаалаад харилцан ялгаатай боловч технологи нэвтрүүлж буй шүүхийн үйлчилгээнд анхаарах ёстой эрсдэлүүд нь нийтлэг байна.

Тиймээс та бүхнийг дараах хэдэн зүйлсэд анхаарлаа хандуулахыг хүсье.

- **“Цахимжилтыг эрчимжүүлэх олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх”** Энэ хүрээнд томоохон төсөл хөтөлбөрийн зорилгыг ийш чиглүүлэх, эксперт солилцох, бусад эрх мэдлийн салаа мөчрийн зүгээс шаардлагатай эрх зүйн баримт бичигт нэгдэж орох хэрэгцээ бий.
- **“Шүүхийн буюу хэрэглэгчийн хяналт”** Цахимжуулалтыг зохион байгуулж байгаа институт ямар байхаас үл шалтгаалж шүүгч, шүүх, хэрэглэгчийн хяналтыг алхам тутамд хангаж, эцсийн бүтээгдэхүүний чанарт онцгой анхаарах шаардлагатай.
- **“Цахимжуулалт шүүхийн шуурхай байдал, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэх ёстой”**
- **“Хүний эрхэд суурилсан цахим шүүхийн стратеги”** шинэ технологи бүрийг дагаж бус менежментийн төлөвлөлт, үзэл баримтлалын хүрээнд хүний эрхийг дээдлэх ёстой.

- **“Хиймэл оюуныг ашиглах ёс зүйн ба хууль зүйн тогтолцоо”** бүрдүүлэх, тэр дундаа шүүхэд хиймэл оюун ашиглах тусгай бодлого, ёс зүйн стандартыг дагаж мөрдүүлэх ёстой.
- **“Уламжлалт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэв загварыг бүрэн халахаас зайлсхийх”** Хэргийн оролцогч, талуудын мэдлэг дутмаг, ахмад настнууд, дэд бүтэц хөгжөөгүй бүсийн оршин суугчдын хувьд шүүхээр хамгаалуулах эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ёстой.
- **“Кибер аюулгүй байдал”** нь зөвхөн байгууллагын биш, “үйлчлүүлэгч иргэн, хуулийн этгээд”-ийн цаашлаад үндэсний аюулгүй байдлын асуудал болох учир онцгой анхаарал хандуулах шаардлагатай.

Эцэст нь, **“хүн төрөлхтөн технологийн ачаар” “нэг шугамд зэрэгцэх бололцоо бүрдэж”** буй энэ мөчид сорилт ба боломжид тулгуурлан, уламжлал – шинэчлэлийг оновчтой хослуулж явах түүхэн үеийг бид өнгөрөөж байна.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Монгол Улсад тавтай саатан морилж, сайхан дурсамж бүтээхийг чин сэтгэлийн угаас та бүхэндээ хүсэн ерөөе.

Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

-----oOo-----

THE ROLE OF DIGITALIZATION AND ARTIFICIAL INTELLIGENCE IN JUDICIAL DEVELOPMENT



Main speech presented at the International Conference organized under the "Open World" Program

(June 16th, 2025)

I extend my warmest greetings to esteemed guests, representatives, and judges.

Although judicial systems vary in their structure and have evolved with unique national characteristics, we are nevertheless confronted with several shared challenges. The globally increasing volume of cases and disputes, limitations in human and financial resources, and the level of public trust in the judiciary—particularly concerning procedural fairness and user satisfaction—are issues that demand constant vigilance. Addressing these challenges through effective and well-calibrated approaches, while continuously improving our systems, forms the cornerstone for ensuring judicial independence and, more broadly, for strengthening the institutional foundation of justice within society.

For Mongolia as well, the issues outlined above have long been a pressing concern and will continue to require increased attention and proactive management. For instance, in 2013, the first instance courts adjudicated a total of 42,580 criminal, civil, and administrative cases. By 2023, this number had increased to 79,759 cases—an increase of 37,179 cases. This

represents an 86.76% rise in the number of cases adjudicated at the first instance level over the past ten years, with projections indicating a continued upward trend.

On one hand, it is encouraging that citizens are increasingly turning to the judiciary—a formal state mechanism—for the resolution of their disputes. On the other hand, however, this growing caseload demands a substantial enhancement in judicial resources, along with further refinement of institutional operations and organizational efficiency.

In such circumstances, the judiciary must not reactively chase challenges, but rather adopt a forward-looking and proactive approach, working with greater efficiency, strategic planning, and smart organization within the limits of its available resources. To that end, embracing “smart digitalization,” advanced information technology, and “cutting-edge artificial intelligence” may provide a viable path forward.

Accordingly, I am confident that in today’s conference, we will openly exchange views, critically examine the current state of judicial digitalization, share best practices and innovations, identify key issues, and explore how the advancement of information technology and artificial intelligence can be effectively utilized to foster judicial development.

“... In such circumstances, the judiciary must not reactively chase challenges, but rather adopt a forward-looking and proactive approach, working with greater efficiency, strategic planning, and smart organization within the limits of its available resources...”

Distinguished colleagues,

I would like to share with you the current state of judicial digitalization in Mongolia and the information technologies being utilized in our judiciary. Additionally, I would like to offer a few reflections on how digital transformation can be enhanced in the context of judicial development and reform.

I. DIGITALIZATION AND THE STATE OF INFORMATION TECHNOLOGY IN THE JUDICIAL SYSTEM OF MONGOLIA

In the modern era, a judiciary must not only uphold independence and impartiality but must also formulate development policies aimed at improving the quality of its operations and services. The goals of digitalizing the judiciary, introducing advanced information technologies, and integrating artificial intelligence serve to reinforce both of these essential aspects.

In Mongolia, there remains an ongoing need to adapt international best practices to our national context, and to regularly evaluate judicial quality across three core dimensions: procedural efficiency, decision-making, and service delivery.

Accordingly, any digital system we implement must be designed to ensure that judicial services are prompt, accessible, transparent, and comprehensible, while also enabling the efficient allocation and use of judicial budgets. It is vital to remember that these objectives stem from the legitimate needs and expectations of both the providers and recipients of judicial services.

International experience shows that courts commonly employ information technologies for tasks such as searching and reviewing documents, assisting in judicial decision-making, and automating case classification, allocation, and workflow processes. For example, according to the inaugural report of the CEPEJ Artificial Intelligence Advisory Board (AIAB), released in February 2025, European countries are currently using 125 technological tools across 8 categories within their judicial systems.

In the case of Mongolia, the introduction of information technology into the judiciary is considered to have begun as early as 1989. As of today, a range of specific judicial functions are being supported—at a functional level—by more than 20 different IT systems, with ongoing efforts to integrate and further develop them in the near future.

“... In the modern era, a judiciary must not only uphold independence and impartiality but must also formulate development policies aimed at improving the quality of its operations and services. The goals of digitalizing the judiciary, introducing advanced information technologies, and integrating artificial intelligence serve to reinforce both of these essential aspects...”

When grouped by purpose of use, the following categories emerge:

1. A platform for the open publication of court decisions and for facilitating access to and analysis of judicial cases

In accordance with the principle of judicial transparency, all judicial decisions—except for those classified as confidential under the law, such as family law disputes—are published openly on the website www.shuukh.mn. As of today, the platform hosts over 547,000 decisions from first instance, appellate, and cassation courts, dating back to 2012.

This digital platform enables users to search previous decisions by date, case category, keyword, legal provisions applied, and name of court or judge, thereby facilitating legal research and providing open access to information.

With more than 1 million visits per month and an average of approximately 40,000 daily visits, the platform has become widely used by the public and legal professionals. To address the growing issue of data overload and improve user efficiency, the integration of artificial intelligence into the platform has been reflected in the “Judicial Development Policy of Mongolia”. The implementation of this enhancement is currently in progress.

“... As of today, the platform hosts over 547,000 decisions from first instance, appellate, and cassation courts, dating back to 2012...”

2. Digital solutions for anonymization and protection of personal data

Following the enactment of the Law on the Protection of Personal Data, which came into force on May 1, 2021, stricter requirements have been imposed on the publication of judicial decisions.

In compliance with the law, personal details such as names of individuals and legal entities, registration numbers, and addresses must be redacted before decisions are made publicly accessible. Given that many decisions span hundreds of pages, manual anonymization is neither feasible nor efficient. Therefore, the Judicial General Council and court administration bodies have implemented digital solutions to automate the anonymization process.

3. Systems for Case Classification, Allocation, and Workflow Automation

Among the earliest components of judicial digitalization implemented globally were case management systems, which remain foundational to digital justice infrastructures. In Mongolia, such systems have been gradually introduced across all levels of specialized courts:

- In 2013, the Administrative Case Registration and Supervision System;
- In 2014, the integrated “Civil-2014” system;
- In 2015, the Mediation Proceedings Registration and Reporting System;
- And in 2017, the Integrated Criminal Case Registration and Supervision System was launched and deployed.

Additionally, the judiciary has been integrated with the government’s inter-agency data exchange platform “KHUR”, allowing courts to retrieve official documents such as verifications and certificates directly from the Judicial E-Reference System for evidentiary use in proceedings.

In 2018, a specialized system was also introduced to manage the participation of citizen representatives (lay assessors) in court hearings.

The use of digital platforms to allocate cases to judges has created an essential precondition for ensuring the right to a fair and impartial trial. These systems facilitate random, anonymous case assignment, thereby eliminating any possibility of prior knowledge or influence over allocation. Importantly, efforts have been intensified since last year to enhance these systems with smart functionalities—including automated classification of cases, similarity detection, algorithmic distribution based on judges’ workload, automation of judicial assistants’ and administrative staff’s tasks, and the generation of automated judicial statistics.

4. Audio-Visual Recording and Livestreaming Technologies

Pursuant to the 2012 Law on the Judiciary of Mongolia, all courts at every level are required to record court proceedings using audio and video technology and to archive the recordings. Since September 9, 2020, the judiciary has operated the www.live.shuukh.mn platform, which provides open access to hearing schedules and summaries, as well as live updates of courtroom proceedings for parties and other interested persons.

Starting from October 2024, the Administrative Chamber of the Supreme Court of Mongolia started livestreaming all public hearings (excluding closed

sessions) through its official website, thereby improving public access to accurate and timely information on judicial activities and the application of the law. This measure represents a concrete step in advancing transparency under Mongolia’s broader judicial reform agenda.

Furthermore, as of January 1, 2025, hearings concerning corruption crimes, as defined under the Special Part of the Criminal Code, are now livestreamed across all court levels—first instance, appellate, and cassation—through both official court websites and social media platforms. These efforts reflect the judiciary’s commitment to continuously implementing timely and incremental digitalization initiatives.

That said, while livestreaming contributes to transparency, it is equally imperative to safeguard fundamental human rights, particularly the right to privacy, and to ensure strict compliance with the principle of proportionality in disclosing court proceedings to the public.

To elevate judicial digitalization to the next level, Mongolia is now taking steps to implement internationally recognized models, such as:

- E-Case Management (digital case workflow management),
- E-Filing (electronic case filing), and
- E-Court (virtual court systems).

“... while livestreaming contributes to transparency, it is equally imperative to safeguard fundamental human rights, particularly the right to privacy, and to ensure strict compliance with the principle of proportionality in disclosing court proceedings to the public...”

Development of the “Judicial Digitalization 2.0 System” officially commenced in 2025.

This new integrated judicial platform will allow individuals seeking to protect their rights to:

- File claims and complaints electronically at any time or place,
- Submit digital evidence,
- Monitor the progress of their cases online,
- Manage their case workflow digitally,
- And exchange information seamlessly with prosecutors, police, and other state institutions via interoperable platforms.

The pilot implementation of this system has already begun at some of the first Instance courts in the Capital City.

II. ENHANCING JUDICIAL DIGITALIZATION FOR DEVELOPMENT

Judicial digitalization must serve two equally important purposes: it must make court services comprehensible and user-friendly for the public—saving them time and money—and it must also reduce the workload of judges and court administrative staff without compromising the quality of their work.

Improving digitalization in the judiciary offers a real opportunity to enhance the efficiency and timeliness of court services.

Under the Law on the Judiciary of Mongolia, the principle of prompt judicial service is a legally mandated obligation. However, due to insufficient staffing, prolonged vacancies, and a consistently high caseload, this principle is increasingly difficult to uphold—making it a critical challenge within the broader context of judicial reform.

For instance, in 2024, a single judge at a civil court of first instance in the capital adjudicated an average of 654 cases. This figure is more than three times the recommended maximum workload of 209 civil cases per judge, revealing the urgent need for systemic solutions.

Moreover, courts are occasionally faced with large, complex cases that require significant resources to process. One recent example involved a case concerning 80 individuals and 4 legal entities, with 545 case files totaling 134,500 pages. In this instance, a case classification and sorting methodology had to be developed, and its implementation highlighted the urgent need for automation. Utilizing specialized software to manage such voluminous case materials could significantly ease the technical workload of judges and their assistants, thereby improving the timeliness and effectiveness of judicial services.

Digitalization plays a vital role in improving the efficiency of judicial operations.

Our experience shows that the initial costs of implementing digital systems—software, hardware, and necessary infrastructure—are often high. Therefore, when planning and budgeting for digitalization, it is essential to conduct cost-benefit analyses and clearly communicate the anticipated impacts and value of such systems not only to Parliament, but also to the public at large.

For example, the 2025 State Budget Law allocates approximately 15 billion MNT for the comprehensive overhaul of the criminal, civil, and administrative

case management systems, which includes the development of a fully integrated E-Filing system based on digital case folders. This amount is expected to rise as additional funds will be required to equip courts with the necessary technology and support the ongoing development of the software systems.

“... in 2024, a single judge at a civil court of first instance in the capital adjudicated an average of 654 cases. This figure is more than three times the recommended maximum workload of 209 civil cases per judge...”

The resulting digital platform must ultimately help ease the workload of legal professionals and improve access to justice for all parties involved. It should reduce the need for physical court appearances, lower expenses, and save time—yielding tangible benefits. Crucially,

such a platform must fully comply with all applicable laws and be flexible and adaptive to legal amendments as they occur.

On a broader level, the attitudinal and cultural acceptance of digitalization is essential. Judicial digitalization must be embraced as a key driver of judicial modernization and future reform. Our approach must remain open, flexible, and grounded in reason.

During the COVID-19 pandemic, one of the most significant challenges Mongolia faced was the transition to remote court hearings. This challenge not only tested our institutional organization but also highlighted the professional capacity and mindset of legal practitioners. It also accelerated digital transformation and generated genuine optimism for the future of judicial digitalization.

Since 2015, Mongolian courts have gradually implemented remote participation in hearings using modern technology. By September 2021, during the height of the pandemic, a total of 35,904 hearings had been successfully conducted online.

Following the pandemic, stakeholders widely recognized that digitalization can measurably improve the accessibility and efficiency of court services—an outcome that stands as one of the most positive and enduring results of this period.

Risks and Safeguards in Algorithmic Case Allocation

Case allocation must remain free from external interference to uphold fairness, prevent corruption and conflicts of interest, and safeguard the

integrity of judicial operations —thereby countering any perception that the judiciary operates "on order."

However, instances of manual interference in case allocation systems — aimed at unlawfully selecting, removing, or reassigning judges, or deleting records without a trace — continue to emerge internationally. Under the guise of "random" allocation, deliberate

"... On a broader level, the attitudinal and cultural acceptance of digitalization is essential. Judicial digitalization must be embraced as a key driver of judicial modernization and future reform. Our approach must remain open, flexible, and grounded in

manipulation of hashed values designed to ensure data integrity has been observed; examples include reducing or skewing judge workloads within the algorithm, altering data records, introducing artificial changes at the coding level, and reassigning judges via administrative override.

The lack of code-level oversight poses a direct threat to judicial independence, transparency, and public trust. Beyond damaging individual judges, such vulnerabilities may compromise the reputation of the judiciary as a whole and foster a system susceptible to political interference and corruption.

To mitigate such risks, it is essential to implement the following safeguards:

- Transparency of allocation algorithms;
- Comprehensive logging and immutable records, preferably through blockchain-based solutions;
- Independent third-party audits;
- Clear role definitions for all participants in the allocation process;
- And the minimization of human intervention.

These measures should be promptly explored and adopted to preserve the legitimacy and integrity of the case allocation process.

Artificial Intelligence and the Challenges and Opportunities of Judicial Digitalization

“... The lack of code-level oversight poses a direct threat to judicial independence, transparency, and public trust. Beyond damaging individual judges, such vulnerabilities may compromise the reputation of the judiciary as a whole and foster a system susceptible to political interference and corruption...”

In discussions on the future of judicial digitalization, artificial intelligence (AI) occupies a particularly prominent place. What was until recently a theoretical concept is now rapidly becoming reality, with breakthroughs emerging not by the year, but by the month and even the day. For the judiciary, this means that while courts must be prepared to adjudicate AI-

related disputes, they must also be ready to strategically and appropriately adopt AI in their own operations—an opportunity that could mark a significant step forward in judicial development.

Internationally, AI is already being used in courts to support a wide range of functions, including case classification, scheduling hearings, providing assistance to court users, researching judicial cases, facilitating settlements in mediation, recording court proceedings, translation, and predicting case outcomes.

In Mongolia, both the Judicial Development Policy and the Strategic Plan of the Supreme Court have articulated a staged approach to introducing AI into the judiciary, with preparatory work currently underway. One notable advantage for the judiciary is that its database of court decisions is relatively well-structured, which offers significant advantages in terms of saving time and labor during AI development. However, it must be remembered that new technologies and breakthroughs are not immune to error and are always constrained by their current capabilities. Any AI-based system is fundamentally limited by the quality and scope of its input data, and we must remain mindful that AI-generated outputs merely reflect the data on which they are trained and, in particular, lack the capacity to bear responsibility.

The examples above demonstrate that AI holds genuine potential to enhance the efficiency and accessibility of justice. However, since each country adopts AI within its own legal and regulatory frameworks, Mongolia must not simply replicate any single foreign model. Rather, it is essential to develop AI tools that are adapted to Mongolia’s national legal system, language, institutional context, and judicial needs, while simultaneously building robust governance and oversight mechanisms.

Moreover, because AI tools are based on language models, countries must invest time and resources in developing high-quality, trusted AI systems in their own national languages, particularly for legal and professional terminology. Although internationally recognized AI platforms support multiple languages, they face significant challenges in terms of data security, national policy alignment, and legal compliance. Mongolia is making commendable progress in developing AI solutions in the Mongolian language, and there is confidence that this progress will continue with increasing accuracy and reliability.

It is also critical to recognize that the use of AI in the judiciary has a direct impact on judicial independence and public trust. For this reason, there is heightened international focus on establishing the proper legal framework for AI in courts.

“... AI-based system is fundamentally limited by the quality and scope of its input data, and we must remain mindful that AI-generated outputs merely reflect the data on which they are trained and, in particular, lack the capacity to bear responsibility...”

The excessive reliance on AI-driven decision-making raises serious concerns about the potential erosion of judicial intellectual engagement in adjudication, the risk of erroneous and unjust outcomes, and emerging threats to personal data protection and non-discrimination. These risks are alarming. Moreover, AI systems are inherently vulnerable to deliberate attacks. The term "adversarial attack" refers to the risk of manipulating algorithms by introducing deliberately misleading data to produce flawed or biased decisions. If judicial AI systems are left exposed to such attacks, their analytical outputs, classifications, and conclusions could be intentionally distorted — resulting in flawed legal analysis and outcomes that are unlawful and unjust.

It is therefore essential to implement robust, layered cybersecurity safeguards within judicial AI systems to detect, prevent, and mitigate such attacks. Without such protections, AI-driven judicial processes risk compromising the integrity of justice itself.

Based on these observations, it is clear that judiciaries worldwide are undergoing an irreversible shift toward digitalization. While this transition varies across jurisdictions depending on national digital infrastructure, energy capacity, educational levels, and sectoral funding, the types of court services being digitalized — and the corresponding risks that must be

managed — are largely common across countries. In this regard, I would like to draw your attention to the following key considerations:

- The digital transformation of the judiciary strongly contributes to achieving numerous international objectives, particularly in the protection of human rights. It is therefore essential to further enhance international cooperation in this field. This calls for aligning major project goals with this objective, fostering expert exchanges, and encouraging other branches of government to join relevant international legal instruments.
- Regardless of whether the institution overseeing digitalization is part of the executive or an independent judicial administrative body, it is imperative to ensure continuous judicial and user oversight throughout every stage of the process, with a particular emphasis on the quality of the final product. This is not merely a technical issue — it directly impacts judicial independence and the impartiality of judges.
- The primary goal of court digitalization must be to improve the quality of justice — namely, its efficiency and accessibility. At the same time, it must be considered that artificial intelligence can neither replace nor assume the humane, professional approach required in adjudication, nor can it make decisions or bear accountability.
- The digital transformation of the judiciary should not simply follow each new technology trend, but must be guided by sound management, careful planning, and a clear conceptual framework. In this respect, it would be optimal to adopt and implement a “Human Rights-Based Digital Court Strategy.”
- It is urgent to establish an ethical and legal framework for the use of artificial intelligence. In particular, the use of AI in courts must be governed by specific policies and enforced ethical standards.
- The shift to digital adjudication should not completely replace traditional procedure, given varying levels of digital literacy and infrastructure among court users. Particular care must be taken to avoid infringing upon the right of vulnerable groups — such as the elderly or residents of underdeveloped regions — to access justice.
- Finally, cybersecurity in the judicial system is not only an organizational concern but also one of individual user protection and, ultimately, national security. It demands the highest level of attention.

In conclusion, as humanity reaches a moment in which technology offers us the opportunity to stand on common ground, we are living through a historic period that calls for skillfully balancing tradition and innovation in the judiciary.

Thank you for your attention.

I warmly wish you an enjoyable and memorable stay in Mongolia.

I also wish this conference every success.